



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/116

Хэрлэн сум

Арга хэмжээнд оролцуулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Нутгийн удирдлагын хөгжлийн институт (LOGODI)-тэй хамтран 2024 оны 04 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрүүдэд хэрэгжүүлэх орон нутгийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалтад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Чимэдбатын Баярцолмонг оролцуулахад 2,000,000 (хоёр сая) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ